



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Халамжийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2024/66/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Ахлах аудитор: Г.Энхтөр Цахим хаяг: ij17.audit@gmail.com	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
---	--	---

## 1.Аудитын санал дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гулаамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734  
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/166

тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ХАЛАМЖИЙН САН ОРОН НУТГИЙН  
ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Халамжийн сан-Орон нутгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Халамжийн сан-Орон нутгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Шилэн дансны сайтад хуулийн 6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл болох 193.5 сая төгрөгийн 15 мэдээлэл байршуулахаас 82.5 сая төгрөгийн дүн бүхий 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

### Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

010020024

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
.	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
3101	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
3102	Банкинд байгаа бэлэн мөнгө/төгрөг/ [4]+[5]	-	-
.	АВЛАГА [7]+[10]	-	-
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН [1]+[6]	-	-
.	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН [13]+[14]	-	-
41	Богино хугацаат өр төлбөр [18]+[21]+[22]+[23]	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [16]+[24]	-	-
41	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
41	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [27]+[28]	-	-
510301	Өмнөх үеийн үр дүн	-	-
5103010002	Өмнөх үеийн үр дүн орон нутаг	-	-
510302	Тайлант үеийн үр дүн	-	-
5103020002	Тайлант үеийн үр дүн орон нутаг	-	-
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН [30]+[31]+[32]+[33]	-	-
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН [29]+[34]	-	-

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Мөр	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО [2]+[3]	73,536,000.00	94,600,000.00
130301	Улсын төсвийн санхүүжилтын орлого	73,536,000.00	-
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтын орлого		94,600,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4]	73,536,000.00	94,600,000.00
2603	Төсөвт төвлөрүүлэх [16]+[17]	4,639,320.00	-
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [39]-р мөр	68,896,680.00	94,600,000.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт		45,600,000.00
2701010900	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	48,444,100.00	-
2701021505	Бусад хөнгөлөлт, тэтгэмжийн зардал	-	-
2701010105	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	3,956,580.00	-
2701023000	ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт		49,000,000.00
2701010106	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	16,496,000.00	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН [10]+[15]+[18]+[40]	73,536,000.00	94,600,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН [9]-[50]	-	-

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	73,536,000.00	94,600,000.00
130301	Улсын төсвийн санхүүжилтын орлого	73,536,000.00	-
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтын орлого	-	94,600,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ	73,536,000.00	94,600,000.00
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	68,896,680.00	94,600,000.00
2701021300	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	-	45,600,000.00
2701021500	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	48,444,100.00	-
2701021604	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	3,956,580.00	-
2701023000	ОНОТүшгэлсэн халамжийн үйлчилгээний зарцуулалт	-	49,000,000.00
2701024000	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	16,496,000.00	-
2603	Төсөвт төвлөрүүлэх [53]+[55]	4,639,320.00	-
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	4,639,320.00	-
.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	73,536,000.00	94,600,000.00
.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

	Сангийн орлого	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
2	Сангийн үйл ажиллагааны зардал [3]+[4]+[5]+[6]+[7]+[8]+[9]+[10]+[11]+[12]	146,400,000.00	94,600,000.00	51,800,000.00
6	Халамжийн сан	97,200,000.00	45,600,000.00	51,600,000.00
8	Олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ	49,200,000.00	49,000,000.00	200,000.00
20	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	146,400,000.00	94,600,000.00	51,800,000.00

### 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 293,472.0 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 293,472.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан байна.

### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого, үр дүнгийн тайланг зэрэгцүүлсэн байдлаар тайлагнаагүй байна.	1	73,536.0			1	73,536.0	1	73,536.0	-	-
Мөнгөн гүйлгээний тайланг зэрэгцүүлсэн байдлаар тайлагнаагүй байна.	1	73,536.0			1	73,536.0	1	73,536.0		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд "тайлант хугацааны батлагдсан төсөв"-ийг тайлагнаагүй байна.	1	146,400.0			1	146,400.0	1	146,400.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>293,472.0</b>	-	-	<b>3</b>	<b>293,472.0</b>	<b>3</b>	<b>293,472.0</b>	-	-

### 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

Шилэн дансанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, хугацаанд нь мэдээлээгүй болон бусад холбогдох хууль, дүрэм журам зөрчсөн 82,500.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 зөвлөмж хүргүүлсэн.

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1	82,500.0	-	-	-	-	1	82,500.0	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>82,500.0</b>	-	-	-	-	<b>1</b>	<b>82,500.0</b>	